



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 521

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Чингис хаан” олон улсын нисэх буудал барих төслийн нэгжээс хүлээлгэн өгсөн 7 нэрийн, нийт 14,910,000.00 (арван дөрвөн сая есөн зуун арван мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ... дугаар сарын ... ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Ширээ	2012	24	50,000.00	1,200,000.00
2	Тумбочкатай ширээ	2012	3	100,000.00	300,000.00
3	Ширээ жижиг	2012	8	40,000.00	320,000.00
4	Хувцасны Шкаф	2012	56	130,000.00	7,280,000.00
5	Ор	2012	64	80,000.00	5,120,000.00
6	Сандал чарган	2012	13	50,000.00	650,000.00
7	Сандал дугуйтай	2012	2	20,000.00	40,000.00
	Нийт дүн			470,000.00 (дөрвөн зуун далан мянга)	14,910,000.00 (арван дөрвөн сая есөн зуун арван мянга)